

Батлав:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Мөнхноён Суврага ХХК-ийн захирал Ситгичай Течатуманан

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ЦАНТ УУЛ “ЧУЛУУН  
НҮҮРСНИЙ” ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН**

**2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-016872 /

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 5314577

Хянасан:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн \_\_\_\_\_

Боловсруулсан:

Мөнхноён Суврага ХХК-ийн байгаль орчны хэлтсийн дарга эсхүл  
\_\_\_\_\_ Ж.Өлзийхутаг

2026 он

## ГАРЧИГ

1	Төслийн танилцуулга.....	2
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл .....	2
2	Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	4
2.1	Баян овоо сумын Байгаль орчны төлөв байдлын товч танилцуулга .....	4
2.2	Өмнөговь аймгийн Баян овоо сумын Налих багийн нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....	5
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	6
3.1	Орчны физик үзүүлэлтэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ .....	6
3.2	Түүх, соёлын дурсгалд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ .....	6
3.3	Төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	6
4	2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	9
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	14
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	15
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	16
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
10	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
11	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	17
	Ашигласан тос, аюултай хог хаягдлыг зохих журмын лагуу хадагалан тээвэрлүүлэх .....	17
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	18
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	21
14	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	21
15	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ.....	22

## 1 Төслийн танилцуулга

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


Монгол улс дах үйл ажиллагааг Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд байрлах “Цант уул” уурхайд явуулж байгаа бөгөөд уг уурхай нь 2013 оноос хойш үндсэн үйл ажиллагаа явуулаагүй, зогсонги байдалтай байсан хэдий ч тухайн жил бүрийн байгаль орчин, орон нутагт чиглэсэн үйл ажиллалгаагаа зогсолтгүй явуулж ирсэн бөгөөд, компаний зүгээс энэ хугацаан дах үйл ажиллагааны хүрээ зөвхөн байгаль орчин, орон нутгийн иргэдийн нийгмийн хариуцлагийн хүрээнд явагдсаар ирсэн.

Төслийн үйл ажиллагаа нь өнгөрдөг тайланд онуудад явах төлөвлөгөө гарсан ч тухайн цаг үеийн байдал нь Ковид-19 цар тахлаас болж зогсонги байдал нь үргэлжилсэн.

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“Мөнх ноён суварга” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Зайсан, “Гэгээнтэн цогцолбор” 202-р байр, 1502 тоот. Утас: (976)-7555-1221, 7555-1331
3	Төслийн нэр	Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт орших Цант-Уул чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах “Мөнх ноён суварга” ХХК
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9011190142 регистрийн дугаар: 5314577 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-016872
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай	Талбайн хэмжээ: MV-016872 – 67992.5 га
6	Ордын геологийн (A+B+C) нөөц	Нүүрс: 27.7 сая.тн
7	Уурхайн жилийн хүчин чадал	Нүүрс: 1.5 сая.тн

**Төслийн байршил:** “Цант-Уул” чулуун нүүрсний ордын лицензийн талбай нь Монгол орны өмнөд хэсэгт Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Налих багийн нутагт дэвсгэрт оршдог. Үндсэн үйл ажиллагаа тус Налих багийн Үнэгэд нэртэй газарт явуулж байна. УБ хотоос урагш 610 км, сумын төвөөс баруун хойш 45 км, Даланзадгад хотоос зүүн урагш 126 км-т тус тус оршино.



*Зураг 1. Лицензийн талбай болон уурхайн байршил*

## 2 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

### 2.1 Баян овоо сумын Байгаль орчны төлөв байдлын товч танилцуулга

**Уур амьсгал:** Уг төслийн талбай орчимд хавар, намартаа сэрүүн, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Энд хавар нь маш хуурай бөгөөд салхи ихтэй. 1976-2019 оны ажиглалтын мэдээнээс үзэхэд тус бүс нутгийн жилийн дундаж агаарын температур  $7.4^{\circ}\text{C}$ , хөрсний дундаж температур  $9.6^{\circ}\text{C}$  байна. Агаарын дундаж харьцангуй чийгшил 39.2%, хур тунадасны дундаж хэмжээ 76.1 мм. Төслийн талбай орчмын салхины дундаж хурд 5.3 м/с, их хурд 33.2 м/с (2015.08) хүрч салхилж байжээ. Тус бүс нутагт баруун зүгийн салхи зонхилдог. Салхины чиглэлийн давтамж сар бүрээр хоорондоо харилцан адилгүй байна. Агаарын сарын үнэмлэхүй их, бага температурын олон жилийн дундаж хэмжээ нь тухайн орон нутаг дахь боломжит хязгаарыг илтгэдэг. 1976-2019 оны ажиглалтын мэдээгээр үнэмлэхүй хамгийн бага температур нь  $-31.5^{\circ}\text{C}$  (2002.12), үнэмлэхүй хамгийн их температур нь  $42.2^{\circ}\text{C}$  (2010.07) хүрсэн байна. Зуны улиралд хөрсний хамгийн их температур нь  $57^{\circ}\text{C}$  (1999.07), өвлийн улиралд  $-27.1^{\circ}\text{C}$  (1977.01) тус тус ажиглагдаж температурын агууриг  $84.1^{\circ}\text{C}$  хүрсэн.

**Гадаргын болон газар доорх ус:** Төслийн талбай ба түүний ойр орчимд тогтмол урсгалтай гол, горхи байхгүй. Хуурай сайр, тойрмууд нь хур тунадас ихтэй үед усаар дүүрээд богино хугацаанд хөрс болон агаарт ууршин шингэдэг. Хүн малын усны хэрэгцээнд голлон гар ба гүний худгийн ус хэрэглэнэ. Төслийн талбайгаас 10 км радиуст буюу нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байхгүй (Улсын усны тооллогын 2003 оны шинэчлэгдсэн дүн, Монгол орны гадаргын усны мэдээ, 2011). Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүс дэх голын сүлжээний нягтшил нь  $0.01 \text{ км}^2/\text{км}^2$ -ээс бага, гол мөрний нийлбэр урсац  $0.5 \text{ л/с} \cdot \text{км}^2$ -аас доош, хур борооны үерийн хамгийн их урсац 10 мм-ээс ихгүй, шар усны үерийн хамгийн их урсац 4 мм-ээс бага, дулааны улирал дахь гадаргын усны ууршилт 1400 мм-ээс их байдаг.

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбай нь нүүрсний орд талбай бөгөөд уг талбай нь говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тачир сийрэг. Хөрс үүсэх явц гандуу нөхцөлд явагдах учир салхины үйл ажиллагаа хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж, ууршилтыг ихэсгэн хуурайшихад нөлөөлж өвс ургамлыг хийсгэн тараах тул зөвхөн үндэсний зарим нь ялзмаг болдгоос органик үлдэгдлийн хэмжээ маш бага, 1%-иас бараг үл хэтэрнэ. Иймээс сайр чулуу ихтэй хуурай хагсуу карбонатлаг байдгаас нийтлэг мараалаг шинж ажиглагддаггүй.

**Ургамлан нөмрөг:** Говийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалан ургамлын нягтшил багатай, сийрэг тачир хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй, энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, шарилж, таана, мангир, хөмүүл, Монгол өвс, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, цулхир, гоёо зэрэг эмийн ургамал, хайлаас, тоорой, сухай, заг, жигд, зэгс, зээргэнэ, бударгана, хармаг, харгана гэх мэт модлог

говь цөлийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирдэг.

**Амьтны аймаг:** Баян-Овоо сумын нутагт хээр цөл, говийн ба хуурай хээрийн амьтад зонхилно. Энд говь цөлийн туурайтан амьтдаас хар сүүлт зээр, махчин амьтдаас хярс, үнэг, жигүүртнээс тас, элээ, ногтруу, хэвлээр явагчдаас зарим зүйл гүрвэл, могой, мэрэгчидээс бор туулай зэрэг амьтад тохиолдоно.

## 2.2 Өмнөговь аймгийн Баян овоо сумын Налих багийн нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Малчдын амьдралын гол эх үүсвэр ноолуур учраас ямааг түлхүү өсгөсөн нь харагдаж байна. Өмнөговь аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 53 багтай. Баян-Овоо сум нь газар нутгийн хэмжээгээрээ 15 сумаас гуравт (15.2 мян.кв.км) ордог бол 2010 онд хийсэн хүн амын тооллогоор 3522 хүн тоологдож аймгийн хэмжээнд хүн амын тоогоороо мөн адил гуравт орсон байна.

### Хүснэгт 2. Хүн ам ба малын тоо толгойн өөрчлөлт

Үзүүлэлт	2002	2006	2008	2012	2016	2020
Суурин хүн амын тоо	2,306	2,418	2,577	2,901	3,022	3,522
Малын тоо толгой	69,3	52,76	62,256	71,285	102,456	96,084

Баян-Овоо сумын өрхүүдийн үндсэн орлогын эх үүсвэрийг авч үзвэл нийт өрхийн 30.2 хувь нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа, 24.8 хувь нь мал аж ахуйн салбарын үйл ажиллагаа, 19.4 хувь нь уул уурхайгаас бусад салбарын цалин, хөлстэй үйл ажиллагаа, 13.9 хувь нь өрхийн хувийн үйлдвэр, үйлчилгээ, 8.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, 3.1 хувь нь бусад үйл ажиллагаа байна. Эндээс уул уурхайн салбар нь өрхийн орлогын нилээд хувийг бүрдүүлж байгаа нь харагдаж байна. Багийн түвшинд авч үзвэл, Налих багийн өрхүүдийн орлого уул уурхайгаас хамгийн их, мал аж ахуйгаас бага хамааралтай байна.

### **3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**

#### **Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**

**Гол нөлөөлөл.** Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь урт хугацааны хүчтэй нөлөөлөл байх юм. Энэ нь төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

Газрын хэвлийгээс ашигт малтмалыг олборлох бүх арга технологиуд газар ба түүний хэвлийг хөндөж, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд их эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлдэг онцлогтой. Голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас нийт 246.97 га талбай шууд сөрөг нөлөөлөлд эрчимтэй өртөнө;
- Тус ордыг ил уурхайн технологиор олборлох бөгөөд төслийн хүрээнд нийт 28393.2 мян.м<sup>3</sup> уулын ажил хийгдэнэ;
- Газар ба түүний хэвлийг хөндөж ландшафт, гео-орчин, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд эрчимтэйгээр нөлөөлнө
- Уурхайн барилга, байгууламж, уурхайн дотоод, гадаад зам, үерийн шуудуу суваг зэрэг техноген нөлөөллүүд үүснэ;

Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөх газрын гадаргын талбайн хэмжээг сөрөг нөлөөллийн төрлөөр ангилан үзүүлэв.

#### **3.1 Орчны физик үзүүлэлтэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ**

Нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагааны үед үүсэх дуу чимээ нь ихэвчлэн хөрс хуулах, нүүрс олборлох, тээвэрлэлт буюу уурхайг ашиглах явцад ашиглаж байгаа машин техникүүдийн хөдөлгүүрээс үүснэ.

#### **3.2 Түүх, соёлын дурсгалд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ**

Уурхайн үйл ажиллагааны явцад археологийн болон түүх, соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй.

#### **3.3 Төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Сумын төсөвт төвлөрөх сан болон хамтын ажиллаганы нөлөөгөөр төслөөс Сумын нийгэм эдийн засагт шууд болон дам байдлаар уурхайн ашигийн хүчин чадлаар, багахан хэмжээний ашиг тустай төсөл юм. Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөлөл нийгэм эдийн засагт байхгүй.

#### **Ашиглалтын хайгуулын ажлын төлөвлөгөө, ажлын хэмжээ**

Уурхайн үйл ажиллагааны хүрээнд, хашаан дотор 2026 оны судалгааны ажлын хүрээнд ашиглалтын талбайн уурхайн ам болон түүний орчимд чанарын судалгаа хийх зорилгоор бага гүнтэй шалгах цооног өрөмдөхөөр төлөвлөсөн.

2026 онд хийгдэх хайгуулын ажлын зорилго нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дээр нүүрсний давхраасын чанарын судалгаа болон давхраасын зузаан болон уналыг нарийвчлан судлахад оршино.

Шалгах цооногуудыг 15-65м хүртэлх гүнд кернтэй (Core) болон нунтаг дээжтэй (RC) нийт 3000 тууш метр өрөмдхөөр төлөвлөж ашиглалтын хайгуулын ажил төлөвлөв.

### Өрөмдлөг тэсэлгээ

2026 оны уулын ажлаар хөрс хуулалт болон өрөмдлөг тэсэлгээний ажил хийнэ.

Нийт 98276 тууш метр өрөмдлөг хийж 3,705 сая м<sup>3</sup> уулын цулд тэсэлгээ хийнэ.

Тэсэлгээнд нийт 1186 тн АНФО болон Эмульсийн тэсрэх бодис хэрэглэнэ.

### Уулын ажлын төлөвлөгөө

2026 оны уулын ажлаар 2,5 сая-аас 3 сая орчим тонн бүтээгдэхүүн олборлох төлөвлөгөөтэй байна.

2026 онд байгуулах овоолгын ажлын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	Нийт
Хөрс хуулалтын хэмжээ	м <sup>3</sup>	5988100
Уурхайн эвдрэлд өртөх талбай	га	10
Овоолгын талбай	га	27.3
Уурхайн хуулах шимт хөрс	м <sup>3</sup>	26000
Овоолгын хуулах шимт хөрс	м <sup>3</sup>	70980
Зам талбай	м <sup>3</sup>	120000
Нийт шимт хөрс	м <sup>3</sup>	216980
Шимт хөрсний овоолгын талбай	м <sup>2</sup>	3,6

### Дэд бүтцийн жагсаалт

№	Цант-уул уурхайн дэд бүтэц	Тоо ширхэг
1	Хотхон	2
2	Оффис / лаборатори	2
3	Уурхай, хаягдлын овоолго	2

4	Засварын газар	2
5	Нүүрс бутлан ангилах үйлдвэр	1
6	Пүү/авто жин / гаалийн хяналтын бүс	1
7	Шатахуун түгээх станц	2
8	Тэсрэх бодисын агуулах	1
9	Цахилгаан халаагуурт нунтаг нүүрсний пиролизийн туршилтын үйлдвэр (Ажиллахгүй)	1
10	Бордооны цэг	1

#### 4 2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Цант уул уурхайн үндсэн үйл ажиллагаа эргээд сэргээхтэй холбоотойгоор 2026 онд байгууллагын Тогтвортой хөгжлийн бодлогод тулгуурлан Усны нөөц баялгийг хамгаалахад чиглэсэн байгаль орчны менежментийн гол зорилт бол төлөвлөлт, үйл ажиллагаагаар дамжуулан нөлөөллүүдийг аль болох багасгах, арилгах, сөрөг нөлөөллийг төслийн талбайн хил хязгаараар хязгаарлах буюу ойролцоох газар нутгийг хамруулахгүй байх явдал байна.

Тус байгаль орчны менежмент төлөвлөгөө нь “Мөнхноён Суварга” ХХК-ийн Цант-Уул нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- Байгаль орчны ауди, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх.
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах.
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарах.
- Компанийн байгаль орчны бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж, төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх.
- БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох.
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах.

**Хүснэгт 3. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний төсвийн хураангуй**

Бүлгийн №	Байгаль орчныг хамгаалах чиглэл	Хийгдэх ажлын тоо	Төлөвлөгдсөн төсөв (төг)
5	Сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээний төлөвлөгөө	9	35,000,000
6	Нөхөн сэргээх төлөвлөгөө	2	6,000,000
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	4	45,900,000
8	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээ	0	0
9	Түүх соёлын өвийг хамгаалах	1	5,000,000
10	Осол эрсдэлийн менежмент төлөвлөгөө	2	14,000,000
11	Хог хаягдлын менежмент	2	12,000,000

12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7	25,000,000
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2	5,500,000
15	Тэрбум модны хүрээнд хийгдэх ажил	3	41,500,000
	<b>БОМТ, ОХШХ – 2026 нийт төсөв</b>	<b>35</b>	<b>208,760,000</b>

**5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Хүлэмжийн хий	Хүлэмжийн хийг ялгаруулж байгаа эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх	Төслийн талбайд	(мэргэжилтний сарын цалин)	1,500,000	1	18,000,000	2026	*MNS ISO 14064-1 -2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)
2.	Агаарын чанар	Зам талбайн тоос дарих бодис ашиглах	Ил уурхай		30,000,000	1	30,000,000	Нэг удаа	Агаарын тухай хууль, 18-р зүйл
		Зам усалгаа			80,000-120,000	3			
		Хорт хийн ялгарлыг бууруулахын тулд дизель станцад хэрэглэх түлшийг хорт хий шингээдэг кальцийн карбонат зэрэг бодистой хамт хэрэглэх	Дизель цахилгаан үүсгүүр, уурхайн суурингийн бага оврын уурын зуух						

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									ашиглалтын бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
3.	<b>Гадаргын болон газрын доорхи усны нөөц</b>	Ил уурхайгаас шавхах усыг байгаль орчинд ээлтэй, зүй зохистойгоор технологийн хэрэгцээнд ашиглах	Уурхайн талбай		Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих ерөнхий шаардлага (MNS 4288:1995)
		Шингэн шатах, тослох материал хөрсөн дээр асгарахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) бэлэн байлгах	Уурхайн талбай		Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	1 удаа	
		Усны тэмдэглэлт өдрийг олон нийтийн усны тухай мэдлэгийг түгээх үйл ажиллагааг зохион байгуулах	Ил уурхай	1	2,500,000	1	2,500,000	1 удаа	
4.	<b>Хөрсөн бүрхэвч</b>	Шимт хөрсний гадаргууг салхинаас хамгаалах тршилт хийх	Төслийн талбай		3,000,000	1	3,000,000	1 удаа	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.	Ургамлан нөмрөг	Байгалийн үрийн сан бүрдүүлэх үе шаттай ажлыг эхлүүлэх.	Ургамалын хамгаалатын хашаанд	-	Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	Хавар, намар ургамалын үр гүйцсэн үеэр нэг удаа	
6.	Амьтны аймаг	Зэрлэг амьтны зам хөндлөн гарч болзошгүй газруудын анхааруулах тэмдэг, пайзийн байршилыг хянах, дагаж мөрдүүлэх	Уурхайн талбай, түүний эргэн тойронд	ш	Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	1 удаа	“Амьтны тухай” хууль (6.1.7)
	<b>Нийт</b>					<b>11</b>	<b>53,860,000</b>		

**6 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	Гадаад овоолго	га	2	Уулын ажлын зардал	Уулын ажлын зардал	2026	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917:2008
	Биологийн нөхөн сэргээлт	Гадаад овоолго	га	2	6,000,000	6,000,000	2026	
	Нийт			2		6,000,000		

**7 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
	Шууд хамгааллын арга хэмжээ	Булгийн эхийг хашаажуулах	Баян-Овоо сумын Налих багийн нутагт	1	30,000,000	35,000,000	2026	Дүйцүүлэн хамгааллын арга аргачлалыг баримтлах
	Шууд хамгааллын арга хэмжээ	“Говийн бага дархан цаазат газрын “А” хэсэг”-ийн хамтран ажиллах биотехникийн ажил хийх	Говийн бага дархан цаазат газрын “А” хэсэг болон Налих багийн Хадах, навтгар хэсэг	2	2,500,000	5,000,000	2026	
		“Говийн бага дархан цаазат газрын “А” хэсэг”-ийн Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт хамаарах хэсгийг хариуцан ажилладаг байгаль хамгаалагчдад техникийн туслалцаа үзүүлэх (мотоцикл, дуран, GPS, бусад тоног төхөөрөмжөөр хангах г.м	Говийн бага дархан цаазат газрын “А” хэсэг	1	4,900,000 (Баян-Овоо сумын нутагт хамаарах)	5,900,000	1 удаа	
	<b>Нийт</b>			<b>4</b>		<b>45,900,000</b>		

### 8 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ байхгүй бөгөөд аливаа орон нутгийн нөлөөллийн бүсийн айлуудыг нүүлгэн шилжүүлэх ажил хийхгүй.

### 9 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Археологи ба палеонтологийн үнэт дурсгалт зүйлс нь аль болох байгалийнхаа байсан газарт нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг. Дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Дахин археологийн судалгаа, хайгуул хийж шинжилгээний үр дүнг мэдээлж болзошгүй аюулд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
- Илэрсэн соёлын болон байгалийн үнэт олдворыг аймгийн засаг дарга бүртгэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд хамгаалалтын бүс байгуулах ба томоохон хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий шинжилгээний байгууллага нь бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлнэ.
- Нүүлгэн шинжүүлэхдээ Монгол улсын ШУА-ын Археологийн Хүрээлэн болон Палеонтологийн төвийн лабораториудад шилжүүлнэ.
- Уурхайн малталт, нүүрс боловсруулах ажиллагаа нь палеонтологийн үлдэц, судлагдаагүй археологийн олворуудад шууд нөлөөлөх тул чухал ач холбогдол бүхий үнэт зүйлсийг зөөвөрлөнө.
- Энэхүү үйл ажиллагааг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргаагын байгууллагад мэдэгдэнэ.
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөнө.

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хүрээнд

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
2.	Төслийн талбайн соёлын өвийн дурсгалт газраар	Соёлын өвийн дурсгалт газрын хашааг сэргээн засварлах	Төслийн талбай	1	5,000,000	5,000,000	1 удаа	Соёлын өвийн тухай хууль
	<b>Нийт</b>					5,000,000		

**10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Гал түймэрээс сэргийлэх	Нийт ажилчдын сургалт	Ажилчид	40	200,000	8,000,000	1	ХАБ-ын тухай хууль
2	Гал гарах	Галтай тэмцэх	Төслийн талбай	1	6,000,000	6,000,000	1	ХАБ-ын тухай хууль
	<b>Нийт</b>					<b>14,000,000</b>		

**11 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хоолны хог хаягдлыг дахин боловсруулах	Ажилчдын хотхон	Техник тоног төхөөрөмжийн зардал	3,000,000	1	3,000,000	1 удаа	Хог хаягдлын тухай хууль
3.	Аюултай	Ашигласан тос, аюултай хог хаягдлыг зохих журмын лагуу хадагалан тээвэрлүүлэх	Уурхайн засварын хэлтэс	Ангилан хадгалсан ашигласан тос цуглуулах нэгдсэн систем байгуулах, аюултай хог хаягдлын тээврийн зардал  (гэрээт компани)	3,000,000	3	9,000,000	2026	Хог хаягдлын тухай хууль
	<b>Нийт</b>					<b>2</b>	<b>12,000,000</b>		

### 12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>							
Тоосны хэмжилт: PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub>	Уурхайн талбайд байршил	Жилд 3 удаа	Удаа/жил	3	2.0	6.0	MNS 5365:2004, Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга. ISO 9855:1993, Гадаад орчны агаар – Агаар дахь хар тугалгын тоосонцорын хэмжээг атом шингээлт спектрометрийн аргаар тодорхойлох арга
Ялгарах бохирдуулагчид: SO <sub>2</sub> , CO, NO <sub>2</sub>	Уурхайн талбайд 5 байршил	Жилд 3 удаа	Удаа/жил	3	2.0	6.0	MNS 5365:2004, Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга. ISO 9855:1993, Гадаад орчны агаар – Агаар дахь хар тугалгын тоосонцорын хэмжээг атом шингээлт спектрометрийн аргаар тодорхойлох арга
<b>ДҮН</b>						<b>6.0</b>	
<b>Газрын доорх ус</b>							
Ca, Mg, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , HCO <sub>3</sub> , Fe, As, Na, K, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, PO <sub>4</sub> , Ni, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be-ийн агууламж, үнэр, өнгө, булингар, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	Нийт 6 цэг	Улиралд нэг удаа (газрын доорх усны чанарын өөрчлөлтөөс шалтгаалан давтамжийг өөрчилж болно)	төг/ жил	4	2.0	8	MNS 0900:2011 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт (MNS 6148:2010) MNS (ISO) 4867:1999 Усны чанар – Дээжлэх Хэсэг 3: Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж MNS (ISO) 5667 11:2000 Усны чанар Дээж авах: 11-р хэсэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар-Дээж авах: 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар (Хяналт шинжилгээний үзүүлэлтүүдийг Цант-Уул төслийн талбайн байгаль орчны төлөв

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
							байдлын үнэлгээний тайлангийн 3.5 Газрын доорх ус бүлгийн судалгааны аргазүйг баримтлан ажиллаж суурь судалгааны үр дүнгүүдтэй харьцуулах)
<b>ДҮН</b>						<b>8,0</b>	
<b>Хөрсөн бүрхэвч</b>							
Ялзмагийн агууламж Урвалын усан орчин (рН) Давсжилт, цахилгаан дамжуулах чадвар (ЕС) Карбонат Хөдөлгөөнт фосфор (P <sub>2</sub> O <sub>5</sub> ), кали (K <sub>2</sub> O)	Уурхайн талбай орчимд 8 цэгт	Жилд 1 удаа	Жил	2	1.5	3,0	MNS 3307-91 хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга. MNS ISO 0390. Хөрсний чанар. рН тодорхойлох арга MNS 4006:1908 Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мичиганы арга MNS 2143:2000 Хөрсний физик шинж чанарыг тодорхойлох лабораторийн арга. MNS ISO 11269-1:2002 Хөрсний чанар. Хөрсний ургамал бохирдуулагч бодисын нөлөөллийг тодорхойлох арга. 1-р хэсэг: Ургамлын үндэсний өсөлт зогсолтыг хэмжих арга.
Хөрсөн дэх хүнд металл ( Сг, Pb, Cd, Ni, Zn)-ын хүлцэх, хортой, аюултай агууламж, мг/кг	Уурхайн талбай орчимд 8 цэгт	Жилд 1 удаа	Жил	2	1.5	3,0	MNS 5850: 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 3297:1991. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ.
<b>ДҮН</b>						<b>6.0</b>	
<b>Ургамлан нөмрөг</b>							
Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га	Уурхайн талбай орчимд 8 цэгт Нөлөөлөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 2 цэгүүдэд Нүүрсний агуулахын хойно 1 цэгт	жилд 1 удаа 8-10 сард хийх	Жил/төг	1	4.0	4.0	Мониторингийн судалгааны өмнө тухайн бүлгэмдэл болон талбайн фото зургийг авч баримтжуулах, 1x1 м талбайд: Бүрхэцийг тусгагийн аргаар үнэлэх. Зүйл бүрийг бүртгэх, Тухайн талбайгаас ургамлын биомассыг зүйл

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Тоосжилтын нөлөө							тус бүрээр газрын гадаргуутай тэнцүүлэн авах, Хяналт, мониторингийн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийн үр дүнтэй харьцуулан дүгнэлт гаргах.
<b>ДҮН</b>						<b>4.0</b>	
<b>Амьтны аймаг</b>							
Зэрлэг ан амьтдын мониторинг хийх	Уурхайн талбай, түүний эргэн тойронд зэрлэг ан амьтдын мониторинг хийж амьтдын байршилд уурхай хэрхэн нөлөөлж буй ач холбогдлыг судлах (Уурхайгаас 3 км-ийн радиуст мэрэгчдийн мониторингийн цэгэн	удаа	төг	1 удаа	1,0	1.0	
<b>ДҮН</b>						<b>1.0</b>	
<b>Цант-Уул нүүрсний ордыг ашиглах төслийн 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв, төгрөг</b>					<b>25.000.000</b>		

### 13 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			4-5-р сар	6-8-р сар	9-12-р сар		
1	2	3	4	5	6	7	
1.	Багийн хуралд танилцуулга хийж оролцох	3,000,000				БО-ны мэргэжилтэн	
2.	Нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах	2,500,000				Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт	5,500,000					

### 14 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1.	Төслийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцогч талууд	Уулзалт	Байгаль орчны ажлын төлөвлөгөө	2026 онд	Дотоод үйл ажиллагааны зардал	Орон нутагтай харилцах албаны мэргэжилтэн	Багийн төв
2.	Төслийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцогч талууд	Уулзалт	Байгаль орчинд хийгдсэн ажлын явц	2026 оны 6-7 сард	0	Орон нутагтай харилцах албаны мэргэжилтэн	Цант уул
3.	Төслийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцогч талууд	Уулзалт	Байгаль орчинд хийгдсэн ажлын тайлагнал	2026 оны 9-10 сард	0	Орон нутагтай харилцах албаны мэргэжилтэн	Багийн төв
	<b>Нийт</b>				Дотоод үйл ажиллагааны зардал		

**15 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ**

2026 онд Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын судалгааг гаргаж, уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 2030 он хүртэлх шат шатны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна.

№	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Мод тарих техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулах	Баян овоо сумын нутаг дэвсгэрт	ш	30,000,000	1	30,000,000	2026 оны 4 сард	Тэрбум мод хөдөлгөөний Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим
2	Мод тарих	Төслийн талбай	ш	2500	1000	2,500,000	2026 оны 4 сард	Мод тарих арчлах гарын авлага, сургалтын материал
3	Мод арчилгаа	Төслийн талбай	ш	5.000,000	1	9,000,000	2026 оны 3-11 сард	Мод тарих арчлах гарын авлага, сургалтын материал
	Нийт					41,500,000		